



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 12 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 180

Улаанбаатар
хот

Төсөл хэрэгжүүлэх тухай

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эрчим хүч, зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Хавсралтад заасан төслийг түлхүүр гардуулах гэрээгээр өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх нөхцөлтэйгээр хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгож, 2017 оны эхний хагас жилд багтаан гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний сайд П.Ганхүү, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ын 40⁵ дахь заалт, “Эрчим хүчний салбарын найдвартай ажиллагааг хангах талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 57 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Зам, тээврийн хөгжлийн сайд

Д.ГАНБАТ

Эрчим хүчний сайд

П.ГАНХҮҮ

ЭРЧИМ ХҮЧ, ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТОМООХОН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	Хариуцах байгууллага
1	Улаанбаатарын III цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх, станцын цахилгаан, дулаан дамжуулах сүлжээг өргөтгөх төсөл	Эрчим хүчний яам
2	Чойбалсангийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар нэмэгдүүлэх, станцын цахилгаан, дулаан дамжуулах сүлжээг өргөтгөх төсөл	Эрчим хүчний яам
3	Багануур-Чойрын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, Багануур дэд станцыг өргөтгөх төсөл	Эрчим хүчний яам
4	Чойрын дэд станц өргөтгөх төсөл	Эрчим хүчний яам
5	Хөшөөтийн уурхайгаас Ховд аймгийн Алтай сум хүртэл 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл	Эрчим хүчний яам
6	Гурвантэс сумын Нарийнсухайтын 270 МВт-ын цахилгаан станц барих төсөл	Эрчим хүчний яам
7	Чойбалсан хотоос Хөөтийн уурхай хүртэл 192 км төмөр зам барих төсөл	Зам, тээврийн хөгжлийн яам
8	Хөөтийн уурхайгаас улсын хилийн Бичигт боомт хүртэл 234 км төмөр зам барих төсөл	Зам, тээврийн хөгжлийн яам
9	Зүүнбаян өртөөнөөс улсын хилийн Ханги боомт хүртэл 281 км төмөр зам барих төсөл	Зам, тээврийн хөгжлийн яам
10	Нарийнсухайтын уурхайгаас улсын хилийн Шивээхүрэн боомт хүртэлх 45.3 км төмөр зам барих төсөл	Зам, тээврийн хөгжлийн яам